



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 07 дугаар сарын 08 өдөр

Дугаар 66

Хэрлэн сум

LXVI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 66 дугаар хуралдаан 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 16:30 цагт цахимаар 92,4 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Улсын Онцгой комиссын шийдвэрээр хот хоорондын хөдөлгөөнийг нээсэнтэй холбогдуулан Хөлөнбуйр сумын хяналтын цэгт иргэдээс түргэвчилсэн шинжилгээ авах талаар санал танилцуулах,

Эрүүл мэндийн газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.1. Хөлөнбуйр сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтэрч буй хүүхэд тус бүрээс коронавирус илрүүлэх түргэвчилсэн шинжилгээг шүлсээр авах,

1.2. Хөлөнбуйр сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтэрч буй нэг хаяг дээр оршин суудаг гэр бүлийн иргэдээс түүврийн аргаар буюу нэг иргэнээс бусад тохиолдолд нэг бүрчлэн коронавирус илрүүлэх шинжилгээг авах, 6 дахь хоногт төлбөртэй шинжилгээг авах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат,


Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
гишүүн Ш.Ёл,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн, хурандаа Б.Бямбаа нарт:

1.3. Шуурхай штабын гишүүд 2021 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс мөн оны 07 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд Шуурхай штабын хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэж ажиллах,

 / М.Бадамсүрэн
/ Хур Г.Нармандах

1.4.Иргэдээс хүсэлт хүлээн авах 70584647.mn цахим хуудсанд ирсэн зөвшөөрөгдсөн ажил үйлчилгээ, зөвшөөрөгдсөн иргэний хүсэлтийг “Зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ын дагуу хяналттайгаар нэвтрүүлэх,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,
Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын
гишүүн Б.Ганганцэцэг нарт:

1.5.Хөлөнбуйр сумын хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж буй албан хаагч нарт аймгийн Онцгой комиссоос гарсан шийдвэр, мэдээллийг танилцуулж ажиллахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ
КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ОРЛОГЧ
ДАРГА, ХУРАНДАА  Г.НАРМАНДАХ

